

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-5
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	6-54
	<p>1.“Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл <i>/Засгийн газар 2019.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/</i></p> <p>2.“Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг</p>	<p>6-10</p> <p>10-24</p>
	3.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2019.09.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	24-54

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
10 дугаар сарын 03-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Х.Нямбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Л.Энхболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Гарамжав;

Тасалсан: Б.Дэлгэрсайхан, Н.Учрал, С.Эрдэнэ.

Нэг. “Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2019.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунбилэг, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир, Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Энхбаатар, Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Г.Гүнжидмаа, Г.Оюунгэрэл, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын менежер Л.Эрдэнэчулуун, Б.Долгорсүрэн, Б.Саруул, Ш.Наранбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, мөн яамны Төрийн сангийн газрын дарга М.Батхуяг, Санхүүгийн бодлогын газрын дарга Ц.Зоригтбат, Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Түвдэндорж, Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга И.Батхүү, Эдийн засгийн бодлогын газрын дарга Г.Батхүрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны дарга Ч.Алтангэрэл, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Э.Батбаяр, мөн зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Мөнхбат, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Д.Дуламсүрэн, мөн газрын ерөнхий нягтлан бодогч Х.Саранчимэг, Цагдаагийн ерөнхий газрын дарга С.Баатаржав, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Н.Алтансүх, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Л.Даваасамбуу, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн, мөн газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газрын дарга Б.Даваажав, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Санхүү төлөвлөлтийн газрын дарга С.Тэрбиш, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, мөн газрын Санхүү, аж ахуйн албаны дарга Б.Цэвэлмаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын

дарга О.Шагдарсүрэн, мөн газрын харьяа Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албаны дэд дарга С.Бямбарагчаа, Дотоод хэргийн их сургуулийн захирал Ш.Лхачинжав, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Л.Баттөр, мөн эмнэлгийн Санхүү хангамжийн албаны дарга Д.Гантуяа, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Д.Батжаргал, мөн хүрээлэнгийн Санхүү, төлөвлөлт хангамжийн газрын дарга Г.Оюунбат, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг, мөн хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч Д.Дэлгэрмаа, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Т.Уранболор, мөн төвийн ахлах нягтлан бодогч Б.Хажидмаа нар оролцов.

Хуралдаанд Хууль зүйн байнгын хорооны ажлын албан ахлах зөвлөх М.Үнэнбат, зөвлөх Б.Баярмаа, Б.Хонгорзул, Г.Золжаргал, референт П.Хулан, Г.Гантулга нар байлцав.

Аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунбилэг танилцуулав.

Аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд оролцов.

Хуралдаанд Хууль зүйн байнгын хорооны ажлын албан ахлах зөвлөх М.Үнэнбат, зөвлөх Б.Баярмаа, Б.Хонгорзул, Г.Золжаргал, референт П.Хулан, Г.Гантулга нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Х.Нямбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд нар үг хэлэв.

Х.Нямбаатар: “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явууля.

Зөвшөөрсөн	4
Татгалзсан	8
Бүгд	12

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 33 минутад хэлэлцэж дуусаав.

Хууль зүйн байнгын хорооны дарга Х.Нямбаатар Улсын Их Хурлын даргын 2019 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 177 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх асуудлыг хэлэлцэх асуудлын гуравдугаарт оруулж хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Улсын Их Хурлын даргын 2019 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 177 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх асуудлыг хэлэлцэх асуудлын гуравдугаарт оруулж хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	3
Татгалзсан:	9
Бүгд:	12

25.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Гурав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.09.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Г.Элбэгсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Л.Мөнхцэцэг, Б.Алтантуяа, мэргэжилтэн Т.Нарантунгалаг, Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Дамдинцэрэн, Улсын ерөнхий прокурорын газрын Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга Б.Бат-Орших, мөн газрын прокурор Ц.Мөнхбат,

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Х.Буянтүмэн, Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Батзориг, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Хууль зүйн байнгын хорооны ажлын албан ахлах зөвлөх М.Үнэнбат, зөвлөх Б.Баярмаа, Б.Хонгорзул, Г.Золжаргал, референт П.Хулан, Г.Гантулга нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хуралдааны үйл ажиллагаанд саатал учруулж, хуралдаан 16 цаг 41 минутаас 17 цаг 18 минут хүртэл саатав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, О.Батнасан нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын газрын Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга Б.Бат-Орших нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Ц.Нямдорж, Ш.Раднаасэд, Б.Пүрэвдорж, Х.Нямбаатар нар үг хэлэв.

Х.Нямбаатар: Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	2
Бүгд	11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 2 цаг 56 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.НЯМБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР
/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Х.Нямбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их хурлын тогтоолын төсөл.

Хоёрдугаарт, Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Улсын Их Хурлын даргын 2019 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 177 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай, өөр асуудал хэлэлцүүлэх саналтай гишүүд байвал саналаа өгнө үү. Өөр саналтай гишүүн байхгүй учраас хэлэлцэх асуудлаа баталъя. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хоёр дахь асуудал. Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцье.

Хоригийг хэлэлцэхтэй холбогдуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболдыг танхимд урья. Энхболд дарга орж ирж байна уу. Материал, санал дүгнэлт хэвлэгдээгүй байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Зандаахүүгийн Энхболд танилцуулна.

З.Энхболд: Гишүүдэд өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн Е/44 тоот албан бичгээр Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан. Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах

тухай Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцлаа.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Хууль зүйн зөрчил маргаангүй явуулбал зохих талаар миний бие 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Е/37 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд сануулан удаа дараа анхааруулсан боловч үл ойшоон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг илэрхий зөрчсөн байдлаар Үндсэн хуулийн асуудалд хандсаныг хүлээн зөвшөөрөх аргагүй байна.

Хууль ёсыг чанд баримталж, нийгмийн зөвшилцөл, ойлголцлын хүрээнд явуулах ёстой Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудалд нэг нам хүч түрэмгийлэн дур зоргын байдлаар хандах нь сайн зүйл авч ирдэггүйг 2000 оны нэмэлт, өөрчлөлтүүд бүрэн харуулсан. Тодруулбал: 2000 оны нэмэлт, өөрчлөлтийг олон нийт дордуулсан долоон өөрчлөлт хэмээн нэрлэж, Үндсэн хуульд орсон цагаас нь хойш өнөөг хүртэл шүүмжилж ирлээ.

Энэ удаагийн оролдлого ч мөн дордуулсан долоон өөрчлөлтийг засна гэсэн уриа лоозонтойгоор эхэлж үл бүтэх байдлаар өрнөлөө. МАН Улсын Их Хуралд үнэлэхүй олонхын суудал авч, төрийн эрхийг дангаар барьж байх үедээ Үндсэн хуульд дордуулсан долоон өөрчлөлтийг оруулсан байдаг бөгөөд уг өөрчлөлт нь улс орны хөгжил, улс төр нийгмийн амьдралд сөрөг муу нөлөө үзүүлсэн тухай шүүмжлэл өнгөрсөн хугацаанд тасраагүйтэй адил тухайн өөрчлөлтийг оруулах үед явагдсан хууль тогтоох байгууллагын хуулийн зөрчил бүхий үйл ажиллагаатай холбогдсон маргаан бас тасраагүй гэж хэлж болно.

Тодотговол Улсын Их Хурал хууль болон тогтоол гаргаж байхаар заасан тухайн үеийн хуулийн тодорхой зохицуулалтыг зөрчиж, 2000 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хууль хэлбэрээр батлаагүйтэй холбогдон үүссэн маргаан, Үндсэн хуулийн цэцийн хэмжээнд олон жил өрнөсөн байх бөгөөд үүний үр дүнд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдсан гэж дүгнэж болохоор байна.

2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан энэхүү журмын тухай хууль нь зарим маргааныг бүрэн цэглэсэн, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон харилцаа, аливаа үйл ажиллагааг нэг бүрчлэн зохицуулсан, чандлан мөрдвөл зохих хууль болсон.

Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг энэ хуульд бүрэн нийцүүлж, хууль зүйн зөрчил, маргаангүйгээр шийдвэрлэх нь зүй ёсны шаардлага болно. Харамсалтай нь Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолоор батлагдсан ард нийтийн санал асуулгад оруулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эх нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн зохих шаардлагыг хангаагүй, уг хуулийг илэрхий зөрчсөн байдалтай байна. Тухайлбал:

1. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь

зөвхөн хууль байна гэж заасан бол тус хуулийн 6 дугаар зүйлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 7 дугаар зүйлийн Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 8 дугаар зүйлийн Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 9 дүгээр зүйлийн Засгийн газар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 10 дугаар зүйлийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлага, 11 дүгээр зүйлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг зохицуулалтууд нь бүхэлдээ Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулна гэдгийг бататган холбогдох харилцааг хоёрдмол утгагүйгээр туйлын тодорхой зохицуулжээ. Хуулийн ийм тодорхой шаардлага зохицуулалтуудыг Улсын Их Хурлын илэрхий зөрчиж Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хууль хэлбэрээр хэлэлцэн шийдвэрлээгүй бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 70 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэсэнд огт нийцэхгүй байгаагаас гадна улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа болсон гол хуульд хууль зөрчсөн байдлаар өөрчлөлт оруулж, нийгмийн зөрчил маргааныг улам дэвэргэх шалтгаан нэмж байгаа нь туйлаас зохимжгүй үйлдэл мөн гэж дүгнэж байна. Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад баримтлах ёстой гол хуулийг илэрхий зөрчсөн Улсын Их Хурлын энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуульд байгуулалд халдсан хэрэг болох тул нийгэмд томоохон эсэргүүцэл, тэмцэл бий болгож, улс орныг бүхэлд нь хямрааж мэдэхээр эрсдэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт энэ хуулиас гадуур Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахыг завдах, хуйвалдан оруулах аливаа үйлдлийг Монгол Улсын Үндсэн хуульд байгуулалд халдсан хэрэг гэж үзнэ гэж маш тодорхой заасныг Монгол Ардын Нам түүнээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд онцгойлон үзэж анхаарвал зохино.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн шаардлагыг зөрчсөн. Үүнээсээ улбаалан тухайн хуулийн олон зүйл заалтыг мөн зөрчөөд байгаа Улсын Их Хурлын үйл ажиллагааг хуулиас гадуур үйлдэл гэж үзэхээс өөр аргагүй бөгөөд хууль ёсны үгүйсгэсэн Үндсэн хуульд байгуулалд халдсан ийм үйл ажиллагаанд нийт ард түмнээ татан оролцуулахыг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн хуулийн шаардлагыг зөрчиж, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн мэдүүлсэн Д.Лүндээжанцан нарын гишүүд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заалтаас гадна 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус зөрчсөн бол хууль зүйн шаардлага хангаагүй төслийг хүлээн авч хэлэлцсэнээр Улсын Их Хурал мөн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10 дугаар зүйл нь Үндсэн хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавигдах шаардлагыг тогтоосон бол тус зүйлийн 10.1 дэх хэсэгт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл нь дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна. 10.1.1-д Үндсэн хуулийн зохих зүйл болон энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимд бүрэн нийцэж байгаа буюу харшлаагүйг нотолсон тайлбар хавсаргасан байна гэж заасан байдаг. Мөн тухайн хуулийн 5 дугаар зүйлд Улсын Их Хурал болон хууль санаачлагч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны бүх үе шатанд 3 үндсэн зарчим баримтална. Эдгээр 3 зарчмын нэг нь Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах зарчим байна гэж заасан бөгөөд энэ зарчмыг Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг заавал хэрэгжүүлэхээр шаардсан 4 төрлийн арга замаар хангаж хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон Улсын Их Хурлын үйл ажиллагааны хүрээнд хуулийн дээрх зарчим, шаардлагууд бүрэн зөрчигдөөд байна. Тиймээс төсөл өргөн мэдүүлэх, хүлээн авах болон хэлэлцэн шийдвэрлэхтэй холбогдсон Улсын Их Хурлын үйл ажиллагааг бүхэлд нь хууль бус буюу хууль бусаар явагдсан гэж дүгнэхээс өөр аргагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1-д Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга, үйл ажиллагаа нь дур зоргын шинжтэй байж болохгүй гэж заажээ.

3. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болно гэж заасан бол мөн хуулийн 10 дугаар зүйлээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлагыг 11 дүгээр зүйлээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх журмыг тус тус хуульчлан тогтоожээ.

Хуулийн эдгээр зохицуулалт Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг нь маргаангүй үйлдлээр хэлсэн бол ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг тогтоосон Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлээр улам бататгасан байна. Тухайлбал тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсэгт ард нийтийн санал асуулгад сонгогчдын нэрсийн жагсаалтад хууль бусаар бичигдсэн нийт иргэдийн олонх нь оролцож, тэдгээрийн олонх нь уг хуулийг зөвшөөрнө гэж санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан тооцно.

17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэгт ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуулийг албажуулах, нийтлэх хүчин төгөлдөр болсонд тооцох асуудлыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо зохион байгуулна. 17 дугаар зүйлийн 17.10 дахь хэсэгт ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуульд Улсын Их Хурал ямар нэгэн засвар өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн Цэц хянан хэлэлцэхийг хориглоно гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалтууд ард нийтийн санал асуулгаар

Улсын Их Хурал хэлэлцсэн хуулийн төслөө оруулж дэмжигдсэн тохиолдолд тухайн төсөл нь хууль болон батлагдана гэдгийг тодорхой зааж байгаа бөгөөд Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолоор батлагдсан ард нийтийн санал асуулгад оруулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эх нь хуулийн энэ тодорхой шаардлагыг огт хангасангүй.

Ард нийтийн санал асуулгыг хууль зүйн ийм илэрхий зөрчилтэйгөөр явуулж, ард түмнийг хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах нь Үндсэн хуулийн дархлааг үгүй хийх, хууль дээдлэх ёсыг устгах, улмаар улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх муу үр дагавартай тул зөвшөөрөх аргагүй юм.

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд бусад шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байна гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-ийн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн заалт зөрчигдсөнөөр хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг, түүнчлэн дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг тус тус зөрчигдсэн гэж үзэж байна.

5.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт Улсын Их Хурал төслийг энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй саналаар тогтвол Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт, 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гаргана гэж заажээ.

Гэтэл Улсын Их Хурал 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг батлахдаа Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтыг үндэсгүй орхиж зөвхөн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэсэн, мөн түүнчлэн ард нийтийн санал асуулгын тухай хуулийг огт үндэслээгүй орхигдуулсан байгаа нь хууль зүйн зөрчилтэй төдийгүй, цаашид гаргах сөрөг үр дагавар ихтэй шийдвэр гэж үзэхээр өөр аргагүй байдалд хүргэж байна. Ард нийтийн санал асуулгыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар бүлгээс гадна ард нийтийн санал асуулгын тухай хуулийн хүрээнд зохион байгуулж явуулах шаардлагатай гэдгийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн "...Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт, 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ард нийтийн санал асуулгыг явуулах тухай тогтоол гаргана гэсэн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг бүрэн тодорхой илэрхийлсэн байна.

Иймд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон ард нийтийн санал асуулгыг явуулах үйл ажиллагааг хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэн Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дэх хэсгийг тус тус үндэслэн

Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний 73 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьж байна.

Энэхүү хоригийг зохих хууль журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү. Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга.

Х.Нямбаатар: За, Энхболд даргад баярлалаа. Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулж, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу. Раднаасэд гишүүнээр тасаллаа. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ хоригийг уншиж үзлээ. Нийтдээ 5 үндэслэл байна. Түүний нэг нь тогтоолтой холбоотой, 5 дахь нь өөрийн чинь уншдаг, ард нийтийн санал асуулга явуулах тухай энэ 73 дугаар тогтоол бол үндэслэх хэсэг болоод бусад зүйлүүд дээр ийм ийм хуулиудыг иш үндэс татаад ингэж оруулах ёстой ч гэдэг юм уу. Бусад 4-ийг нь харахаар нөгөө хоёрдугаар хэлэлцүүлгийг давсан, Үндсэн хууль руу орсон юм байх юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавихдаа Улсын Их Хурлаас баталсан хууль болон Улсын Их Хурал бусад шийдвэрийн төсөлд хориг тавих ёстой. Тийм үү. Тэр бол Үндсэн хууль дээр өөр дээр нь бичээд тавьсан. Одоо хоёрдугаар хэлэлцүүлэг дээр яригдаад, сая хоёрдугаар хэлэлцүүлэг дээр санал аваад дэмжигдсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол би төсөл гэж хараад байх юм. Үүн дээр тодруулга авмаар байна. Энэ яваандаа энэ хориг хэрвээ хүлээж авахгүй гээд, бүлгийн шийдвэр гарсан гээд, ингээд Их хурал дээр очоод хүлээж авахгүй гээд нэг юм үүснэ.

Хоёр дахь асуултыг Байнгын хорооны даргаас асуух гэж байна. Гэтэл Үндсэн хууль батлагдаад явсны дараа юу болох вэ. Ерөнхийлөгч ёсчлох ёстой. Төрийн тамгыг дарах ёстой Үндсэн хуулийн батлагдсан эх дээр. Би тухайн үедээ ийм ийм хориг шаардлагыг тавьсан. Гэтэл та бүхэн Улсын Их Хурал хүлээж аваагүй учраас үүнийг ёсчлох боломжгүй байна гэдэг юм, хоёр дахь нь Үндсэн хууль, батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн цэц дээр очих асуудал үүсвэл яах вэ, тэр үед Үндсэн хуулийн Цэц Ерөнхийлөгч тухайн үед агуулгын хувьд Үндсэн хууль дээр хоёрдугаар хэлэлцүүлэг давсан төсөл дээр чинь хориг тавьсан юм байна шүү дээ гэдэг ийм авцалдаагүй юм, мухар тойрог эх үндэсгүй тоглоом руу бид нар орох гээд байна л даа. Үүнийг яг яаж харж байна. Энхболд дарга өнөөдөр хоёрдугаар хэлэлцүүлэг гээд дэмжигдсэн байгаа төслийг төсөл гэж харж байгаа юм уу, хууль гэж харж байгаа юм уу, Үндсэн хууль дээр бичсэн Ерөнхийлөгчийн бүрэн эрх дотор байгаа батлагдсан хууль, тогтоол дээр хориг тавина гэдэг заалт чинь хэвээрээ л байгаа санагдах юм. Үүнийг тайлбарлаач.

Хоёр дахь асуултыг Нямбаатар дарга Цэц дээр очвол яах юм, хэрвээ үүнийг ёсчлохгүй гээд Ерөнхийлөгч тамга дарахгүй байвал яах юм, ийм зүйл байна.

Гурав дахь юм нь энэ Байнгын хорооны даргаас асууя. Энэ 73 дугаар тогтоол байна шүү дээ, түрүү Ерөнхийлөгчийн 5 дахь үндэслэл дээр заасан нэг зүйл 17.1 гээд, үүнийг харахад бас эргэлзээтэй юм байна шүү. Энэ тогтоол дотор чинь энэ ард нийтийн санал асуулга явуулах тухай Их Хурал зарласан бол зарласнаас хойш 21-45 хоногийн дотор, өдрийг нь товлон зарлана, энэ тогтоолтой хамт явах ёстой юм биш

үү тэр өдөр нь. Их Хурал дээр энэ тогтоолыг батлахад би араас асуусан. Хоногийг нь яагаад тавихгүй байгаа юм бэ гэсэн, тэгээд чимээгүй чимээгүй гэсэн юм яриад алх цохиод явсан. Үүнийг, 73-ийг дагаад өдөр тогтоох тогтоол гарах ёстой юу. Тэр нь ямар хуулиар гаргах гэж байгаа юм. Би 5 дугаар үндэслэлээр Ерөнхийлөгчийн тавьсан энэ юм бол яах вэ, агуулгын хувьд биш ч гэсэн хэлбэрийн хувьд тогтоол чинь өөрөө бас асуудалтай юм биш үү гэдэг нь аль аль талдаа харж үзэх ёстой юм байна л гэж харагдаж байгаа. Тийм учраас энэ 3 асуултад хариулж өгөөч гэж.

Х.Нямбаатар: Энхболд дарга Раднаасэд гишүүний асуусан асуултад хариулъя.

3.Энхболд: Ерөнхийлөгч хориг тавиад байгаа нь энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг явуулах гээд байгаа юм. Яг энэ 2000 оныхоо алдааг Улсын Их Хурал давтаад байгаа учраас энэ алдаагаа давтахгүй байгаач гэж байгаа юм. 2000 онд хууль гэдгээр батлаагүй гэдгээр унасан. Одоо хүртэл Цэцээс хоёр шийдвэр гарсан байгаа шүү дээ. Хүчинтэй, хүчингүй гэдэг. Цэц бол түүнээсээ буцахгүй юм билээ. Тэгээд Чимид гуайн 2010 оны хуулийг гаргаж байгаа нь тийм учиртай юм. Одоо дахиж нэмэлт, өөрчлөлт хийх бол ийм журмаар явна шүү гээд, тэгээд тэр хууль дотор нь эхлэхээсээ дуусах хүртэл хууль байна хууль байна гээд бичсэн байгаа шүү дээ. Тэгээд үүнийгээ болохоор мөрдөөгүй, энэ хууль яах вэ дээ Үндсэн хуульд нь нэмэлт өөрчлөлт гээд бичсэн юм чинь тэгээд явъя гээд ингээд дур зоргоороо шийдээд байгаа учраас үүнийгээ зөв болго, яг л 1999 оны өөрчлөлтийг хүчингүй болгодог шиг Цэц үүнийг хүчингүй болгоход бэлэн байгаа шүү гэж сануулж байгаа юм. Хоёрдугаар үндэслэл нь болохоор техникийн алдаа гарсан, түүнийгээ засахгүй бол Улсын Их Хурлын ард нийтийн санал асуулгаа явуулах шийдвэр өөрөө Үндсэн хууль зөрчсөн болох гээд байгаа юм. Маш ойлгомжтойгоор 25.1.16 үндэслэл гэж журмын тухай хуульд зааж өгсөөр байтал эргээд түүнээс зайлсхийж байгаа юм шиг бичихгүй байгаа юм. Энэ хоригийг хүлээж аваад энэ алдаануудаа засаад уг батлагдсан агуулгатай бол Ерөнхийлөгч ямар ч яриа байхгүй байгаа юм. Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэхдээ 1999 оны алдааг засах гэж гаргасан журмын дагуу хуулиа дахиж өөрчлөөд яг тэр алдаагаа тэр чигээр нь давтаад байгаа нь буруу байна гэж байгаа юм.

Улсын Их Хурлын 33 дугаар зүйлийн 1.1 дээр Улсын Их Хурлын баталсан хууль бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавих гэдэг Ерөнхийлөгчийн бүрэн эрх байгаа. Энэ бол Улсын Их Хурлын баталсан шийдвэр мөн, хэдийгээр ард нийтийн санал асуулгаар эцэслэн батлагдахаар явж байгаа ч гэсэн энэ явцдаа процедураа, дэгээ журмаа зөрчихгүй яваад, түүгээрээ батлагдана уу, гуравдугаар хэлэлцүүлгээр батлагдана уу ямар ч байсан Цэц дээр очоод унахааргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй бол 1999 оны алдаа бол давтагдах гэж байна шүү гэж сануулж байгаа юм.

Раднаасэд гишүүний сүүлчийн асуулт бол гараагүй тогтоолын тухай яриад байгаа юм. Гараагүй тогтоол чинь энэ 73-тайгаа цуг тэр дотроо ороод тэдний өдрийн тэд, тэдэн сарын тэдний өдөр явуулсугай, тэдэн төгрөг зарцуулсугай гэдэг юм чинь энэ тогтоолд байх ёстой юм л даа. Тэр тогтоол нь гаралгүй хоёр долоо хоночихлоо. Энэ тогтоол гарснаас хойш. Тэгэхээр тэр тогтоолыг Улсын Их Хурал өөрөө гаргаж чадахгүй, зардлын асуудлыг олон юм гацчихаад байгаа юм билээ. Тэгэхээр энэ хориг

дээр хоёрдугаар хэлэлцүүлгээр тохирсон юмаа цааш нь явуулах гарцаа зөв олох боломж олгож байгаа болохоос Үндсэн хуулийн өөрчлөлтийг эсэргүүцээд, ард нийтийн санал асуулгыг эсэргүүцээд байгаа юм байхгүй.

Улсын Их Хурал шийдвэрээ 1999 оных шиг алдаагүйгээр гаргачхаасай гэж л хориг тавьж байгаа юм.

Х.Нямбаатар: Энхболд даргаа би эхлээд таны хариулт, тайлбар гэсэн дээр 2-3 зүйл хэлье. 2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдаагүй байсан. 2010 онд батлагдсан. 2000 онд Үндсэн хуулийн цэцэд иргэн /Амарсанаа,/ Нарангэрэл, Хайдав, Баасанжав, Чулуунжав, Жамбалдорж нарын хүмүүс мэдээлэл гаргасан. Энд нэг ч хуулийн төсөл гэдэг тийм төсөл хэлбэрээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталснаас болж, төсөл хэлбэрээр батлаагүйгээс болж Үндсэн хууль зөрчсөн тухай ийм мэдээлэл гаргаагүй. Дараах 6 асуудлаар мэдээлэл гаргасан.

Нэгдүгээрт, Үндсэн хуулийн Цэцээс санал аваагүй, Ерөнхийлөгчтэй зөвшилцөөгүй, сонгогчид олон нийтээр хэлэлцүүлээгүй гэдэг нь нотлогдож байна. Хоёрдугаарт, иргэд болон улс төрийн бусад намын саналыг аваагүй нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна гэсэн эрхийг зөрчсөн байна.

Гуравдугаарт, Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн утга агуулгаас үзэхэд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгын талаарх саналыг Үндсэн хуулийн Цэц Их Хуралд өргөн мэдүүлж болно гэж заасан байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн Цэц болон Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн талаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх эрхтэй болох нь тодорхой байна.

Дөрөвдүгээрт, Улсын Их Хурал Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хууль түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн саналаар батална гэж заасныг зөрчсөн байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ирцийн бүрдэл хангаагүй байхад Улсын Их Хурал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж баталсан байна.

Тавдугаарт, Нэмэлт өөрчлөлт бүхэлдээ Үндсэн хуулийн 20 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Их Хуралд хадгална. 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч төлөөлөгч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэдгийг зөрчжээ гэсэн ийм асуудлаар мэдээлэл гаргасан. Үүний дагуу Үндсэн хуулийн Цэц асуудлыг хэрхэн шийдсэнийг бид бүхэн мэдэж байгаа. Тэгэхээр таны саяын тайлбар бол мөн Ерөнхийлөгчийн хоригт дурдсан зүйл маань өөрөө зөрчилдөөнтэй байна гэдэг талаар би хэлье.

Хоёрт гэвэл Раднаасэд гишүүн сая надаас 3 асуулт асуусан. Нэгдүгээрт, Ерөнхийлөгч энэ процесст чинь хоригтой холбогдуулж ойлголцож Үндсэн хуулийн

асуудлыг шийдэж явахгүй бол Үндсэн хуулийн эцсийн үе шат болох эх хувь дээр ёсчлох энэ процессыг хийхгүй байвал юу болох вэ гэж байна.

Хоёрдугаарт, энэ асуудал маань хоригийг хүлээж аваагүйгээс эцэст нь Цэцэд ямар үр дагавар үүсэх вэ гэж байна.

Гуравдугаарт, ард нийтийн санал асуулгатай холбогдуулж тэр тов тогтсон хугацааны тов тогтсон шийдвэрийг дахиж тогтоол хэлбэрээр гаргах уу гэж байгаа юм. Гурав дахь асуудал бол угаасаа тов тогтсон, дахиж тогтоол гаргая гэдэг байдлаар хамгийн сүүлд чуулган дээр энэ асуудлыг ард нийтийн санал асуулга явуулах шийдвэр гаргая, хуулийн хугацаанд нь ард нийтийн санал асуулга явуулах тов тогтсон тогтоолоо зардал болон бусад зүйлтэй нь хамтад нь шийдэж гаргая гэсэн ийм шийдэлтэй, даргын зөвлөл дээр ч ингэж ярьсан. Тэгэхээр энэ асуудлыг хоригийг хүлээж аваагүй тохиолдолд энэ процесс цаашид үргэлжлээд ард нийтийн санал асуулгын тухай цаашаа дараагийн асуудал өрнөх байх. Эхний хоёр асуудал дээр би Ерөнхийлөгчийн өмнөөс хариулах нь өөрөө ёс зүйн тийм надад тийм эрх хэмжээ байхгүй, Цэцийн өмнөөс мөн адил урьдчилан зөгнөж Цэцийн өмнөөс шийдвэр гаргах боломжгүй. Би 1999, 2000 оны Цэцэд шийдвэрлэсэн маргааны талаар бас Та бүхэнд товч сая хэллээ. За өөр асуулттай гишүүд байна уу. За, Мөнх-Оргил гишүүн, Нямдорж гишүүн.

Ц.Мөнх-Оргил: За баярлалаа. Энхболд даргаа таны саяны тайлбараас Раднаасэд гишүүний асуултад хариулсан тайлбараас би ингэж ойлголоо шүү дээ. Нэгдүгээрт, Ерөнхийлөгч хоригтой заасан техникийн алдаануудыг засаад оруулаад ирэх юм бол Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа юм байна. Ард нийтийн санал асуулгатай асуулгагүй гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлгээр хийгээд явсан ч гэсэн ард нийтийн санал асуулга хийсэн ч гэсэн Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа юм байна гэж би ойлголоо. Би зөв ойлгож уу буруу ойлгож уу.

Хоёрт, ард нийтийн санал асуулга дээр Ерөнхийлөгчийн байр суурь ямар байгаа юм бэ. Явуулах нь зүйтэй гэж үзэж байгаа юм уу, явуулах хэрэггүй, Их Хурал өөрийн энэ асуудлаа хэлэлцээд шийдвэрлэх бүрэн эрх нь байна гэж үзэж байгаа юм уу, үүнийг тодотгож, саяын хэлсэн ярьсан тайлбараас чинь тодруулж асуумаар санагдаж байна.

Х.Нямбаатар: 2 дугаар микрофон, Энхболд дарга.

3.Энхболд: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Ер нь бол ард нийтийн санал асуулга 30 тэрбум төгрөгөөр явуулахын эсрэг байгаа юм. За, үгүй гэдэг хоёрхон асуултад хариулт авахын тулд 30 тэрбум төгрөг хайран байна. 30 тэрбум төгрөгөөр санал асуулга явуулахаар шийдээд, 11 сарын сүүлээр ч юм уу хүйтэрсэн үед ирц хүрэхгүй бол яах вэ, салхинд хийсгэсэн ажил гарна. Улсын Их Хурал гуравдугаар хэлэлцүүлгээрээ батлаад бүрэн хүчинтэй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх боломж байна. Энэ аргаараа яагаад явж болдоггүй юм бэ?

Агуулга дээр Ерөнхийлөгчид хэлэх үг байхгүй. Яагаад гэвэл хэлэлцүүлгийн явцад нэг хэсэг оролцсон. Тийм учраас агуулгыг зөв буруу гэж ярихгүй. Яагаад

Үндсэн хуулийн Цэц дээр хууль гэдгээр яваагүй юм, уначхаж магадгүй гээд байхаар 2013 оны 10 дугаар сарын 11-нд Үндсэн хуулийн Цэц, Цэцийн гишүүн Жанцан гэдэг тухайн үед дарга байл уу, хүний тогтоол байгаа юм. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсэхээс татгалзаж байгаа.

Иргэн Ариунболд гэдэг хүн энэ 2010 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.2.4-ийг буруу гэж маргасан юм билээ. Энэ Үндсэн хуульд чинь өөрт нь хуулиар өөрчлөлт хийгээгүй, нэмэлт өөрчлөлт хийгээд болсон байхад энэ хууль чинь буруу болсон байна. Тэгэхээр 1999 оны өөрчлөлт чинь зөв байсан.

Тэгэхээр үүнийг хүчингүй болгож өгнө үү гэдэг хүсэлт гаргахаар Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Жанцан юу гэж хэлсэн бэ гэхээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа зөвхөн хууль батлан гаргахаар зохицуулсан нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах тул иргэн Ариунболдын мэдээллийн шаардлагад дурдагдаж буй Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаа үүсэхээс татгалзсугай гэж. Тэгэхээр энэ юу гэж байна вэ гэхээр Чимид гуайн 2010 оны хуулийг заавал мөрд, сая миний уншдаг эхний 1-4 дээр хууль хэлбэртэй байна, хуулийг хэлэлцэнэ гээд энэ бүх зүйл явахгүй бол Үндсэн хуулийн Цэц хүчингүй болгох боломж нь байж байна шүү гэж, үүнийг гишүүдэд тарааж өгч болно, Нямбаатар даргын хэлдэг маргаан бол 2007 оныг дуустал үргэлжилсэн байгаа юм. Тэгээд яах вэ, энэ өөрчлөлт нь маргаан үүсэхгүй гээд хамгийн сүүлийн бичиг нь 2007 оны 3 дугаар сарын 12-ны Тамгын газрын даргын бичиг яваад байгаа юм.

Энэ бүх байдлаас дүгнэлт хийхээр Цэц бол ийм л ойлголттой байж байгаа, 1999, 2000 оны өөрчлөлт бол саяын Нямбаатар гишүүний хэлдэг шиг олон юм байгаа боловч хууль байна, ахиж ийм 1999, 2000 оных шиг яаруу сандруу өөрчлөлт хийхгүйн тулд 2010 онд энэ хуулийг гаргаад, одоо энэ хуулийнхаа дагуу нэмэлт, өөрчлөлтөө хийх болов уу гэж бодоод сууж байгаа улсууд шүү дээ. Гэтэл тэр хуульд байгаа хамгийн гол заалтуудыг хэрэгсэхгүйгээр Үндсэн хууль гэдэг үг байхгүй байна гэдгээр Лүндээжанцан гишүүний олон газар тайлбарласнаар ингээд явчих юм бол яг нөгөө хүчингүй болох болзлоо хангачаад байгаа учраас л тэгээд байгаа юм.

Одоо хэргийг хэсэгчлэн авна уу, бүрмөсөн авна уу, ард нийтийн санал асуулга явуулах тогтоолдоо заавал за гэсэн хоёр Үндсэн хуулийнхаа хоёр заалтыг үндэслээд, тэгээд... /үг тасрав/

Х.Нямбаатар: За нэмэлт 2 минут. 3 дугаар микрофон.

З.Энхболд: Тэгээд 30 тэрбум төгрөггүйгээр ард нийтийн санал асуулгаар оруулна уу, оруулахгүй байна уу баталсан байхад Үндсэн хуулийн Цэц дээр очоод унахааргүй өөрчлөлт хийсэн байхад Ерөнхийлөгч дэмжээд л явна. Тэрнээс энэ процедурын хууль байна гэсэн үг, тэгээд 25.1.16-г үндэслээгүй байна гэдэг жижиг сажиг процедурын алдаанаас болоод, энэ арай хийж хийсэн өөрчлөлт чинь өөрөө бүхэлдээ хүчингүй болбол хайран байна гэж байгаа юм.

Х.Нямбаатар: За баярлалаа. Нямдорж гишүүн.

Ц.Нямдорж: Би сая Мөнх-Оргил гишүүний асуусан асуултыг асуух гэж байсан юм. Гуравдугаар хэлэлцүүлэг хийгээд тэгээд дараагийн юмаа хийгээд баталбал энэ Үндсэн хуулийн өөрчлөлт цаашдаа хэл амгүй явна гэж ойлгоод л, тийм ойлголт л байгаад байгаа юм. Сая Энхболд дарга ийм хариулт хийсэн учраас би асуултаасаа больж байна.

Илэрхий санал нийлж байгаа нэг юм надад байгаа энэ хоригт, зардал их байна гэдэгтэй би бүрэн дүүрэн санал нэг байгаа. Арай хэтэрч байна шүү дээ. Саяхныг хүртэл Их Хурлын сонгуулийг 3-5 тэрбум төгрөгт багтаагаад л хийдэг байсан шүү дээ. Энэ чинь за, үгүй гэсэн асуулттай ганц юманд нэг дугуйлаад гарах ажилд 20-30 тэрбум төгрөг зарна гэж ер нь юу байх вэ дээ. Би энэ хоригийг хүлээж авах нь зүйтэй гэж бодож байгаа.

Улс төрийн мухардмал байдал бий болохоос зайлсхийх бололцоо өгч байна гэж ойлгож байгаа. Энэ хэлэлцээд байгаа асуудлаар чинь 2 жил Лүндээжанцан нарын ажлын хэсэг чинь баахан аймаг, сумаар явж суртал ухуулга хийсэн биз дээ. Санал авсан биз дээ. Санал авсны үндсэн дээр энэ төсөл босгосон биз дээ. Хэчнээн ч их зардал гаргаж байна. Би энд Хууль зүйн байнгын хорооны гишүүдийг энэ асуудалд хуулийн талаас нь хандаж, энэ төр түмэн амгалан байх талыг нь бодож энэ хоригийг дэмжээсэй гэж бодож байна. Би яагаад ийм юм ярьж байна вэ гэхээр үүнийг дэмжсэн, үгүйсгэсэн цаашдын хэл яриа тасрахгүй, аягүй бол зарим хэсэг нь жагсаал цуглааны хэлбэрт шилжиж, эсэргүүцэл маягийн үйлдэл хийхийг үгүйсгэх арга байхгүй. Энэ тохиолдолд энэ хэдэн цагдаа л ажилладаг шүү дээ. Нийгмийн олон нийт, аюулгүй байдал гэдэг талаас нь. Би ажлаа ч гэсэн бодож энэ хоригийг хүлээж авах ёстой гэдэг саналыг хэлж байгаа юм. Ийм зүйл байна. Тэгээд хоригийн учир начир ойлгомжтой болж байгаа учраас Байнгын хорооны гишүүд Ерөнхийлөгчийн хоригийг дэмжих байх гэж бодож байна шүү дээ. Ер нь аливаа асуудлыг зардал багатай шийдэх арга цаашдаа бодож байх хэрэгтэй дээ. Хэтэрхий ач холбогдолгүй юманд дэндүү их зардал гаргаж, ингэж явдаг ажлын арга барил буруу шүү.

Х.Нямбаатар: За, би үг хэлье. Ард нийтийн санал асуулга явуулахаар үймээн самуун гарна гэдгийг би ерөөс ойлгохгүй байгаа юм. Хоёр гэвэл хаанаас Энхболд дарга, манай Нямдорж дарга нар 30 тэрбум төгрөг яг хаанаас төсөвлөөд зарцуулахаар, Их Хурал ямар ч шийдвэр гаргаагүй байгаа. Зардалтай холбоотой. Их Хурлын гаргах шийдвэрийг бид нар урьдаас зөгнөөд дүгнээд ярих боломжгүй байх гэж бодож байна. Хоёрт гэвэл зардалгүй шийдэх, яг ард түмнээсээ асууя, та бүгд бид хамтран амьдардаг энэ гэрээг ард түмэн өөрсдөө эцэслэн шийд гэдэг энэ эрхийг Үндсэн хуульд заасан зарчмын дагуу өгөхөөр ээлжит сонгуультай ч явуулж болно шүү дээ. Ерөнхийлөгч 7 дугаар сарын 16-нд ирүүлсэн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, санал гэж ирүүлсэн шүү дээ. Одоогоос 2 сарын гаруйн өмнө. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хоёр хууль зөрчилдөөнтэй бол алийг нь дагах вэ?

Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрийнх нь зохицуулалтыг өөртөө шингээсэн. Нийт гишүүд өөрсдөө баталж болно, эсвэл ард нийтээрээ эцэслэж батлуул гээд. Би түрүү Раднаасэд гишүүний асуусан асуултын юуг харлаа, одоо журмын хууль гээд үнэхээр хууль хүчин төгөлдөр гэж

үзэж байгаа бол журмын хуулиа 17 дугаар зүйлийн 10-т ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуульд Улсын Их Хурал ямар нэгэн засвар өөрчлөлт оруулах Үндсэн хуулийн Цэц хянан хэлэлцэхийг хориглоно гэсэн эрхийг ард түмэнд өгсөн.

Тэгэхээр ийм мөнгө төгрөг, 7 дугаар сарын 1 шиг үймээн самуун гарна гэдэг бол ээлжит сонгуулиар ард нийтээсээ санал асууя гэдэг саналыг би Их Хурлын гишүүний хувиар гаргая гэж бодож байна. Хоёр дахь тогтоолын төслийг хэлэлцэхэд.

Энхболд даргын хувьд сая 10 минутын зайтай хоёр өөр агуулгатай зүйл ярьсан. Хэдүүлээ энэ микрофон, бүгд энэ танхимд 20-30-аад хүн сууж байх шиг байна. Ерөнхийлөгч бол угтаа ард нийтээс асуух гээд байгаа юм нэг, хоёр дахь нь зөвшилцөөгүй саналаа эргээд нэг харъя гэсэн санаа байгаа, гурав дахь нь болохоор ард нийтийн санал асуулга явуулалгүй гурав дахь шууд баталдаг эрхээрээ батлаасай гээд, тэгээд танай институтээс барьж байгаа байр суурийг би ерөөсөө би хувь хүний хувьд ойлгохгүй байна. Засгийн бүх эрх мэдэл ард түмний гарт байгаа бол энэ суурь хуулиа батлах эрхийг нь ард түмэндээ өгөөч гэдэг ийм үгийг хэлье.

Пүрэвдорж гишүүн үг хэлье гэсэн. Тийм ээ.

Б.Пүрэвдорж: За тэгэхээр засаглалыг, хямралыг зохицуулъя. Ер нь гүйцэтгэх эрх мэдэлтэй, засаглалтай, гүйцэтгэх эрх мэдлийг нь өгсөн шиг өгье гэдэг ийм санаачилгын дагуу энэ Үндсэн хуулийн өөрчлөлт явсан. Харамсалтай нь энэ үндсэн зорилгодоо хүрэхгүй, дээрээс нь хариуцлагын асуудлыг нэг мөр шийдэж чадахгүй тийм мөлгөр Үндсэн хуулийн өөрчлөлт болж хувирч байгаа. Энэ Үндсэн хуулийн мөлгөр өөрчлөлтийгөө ерөөсөө гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлгээр яваад өөдтэй юм болохгүй болох шинжтэй болонгуут ард нийтийн санал асуулга явуулаад, ард түмэн за гэсэн юм чинь баталъя гэдэг ийм л зам руу ардын нам орж байгаа л даа.

Үүгээр юу ч өөрчлөгдөхгүй байгаа. Дордохын долоон өөрчлөлтийг засах юм нэг ширхэг ч байхгүй. Ганцхан нэг зүйл дээр хэлсэн ухаантай, өөр өөрчлөлт ерөөсөө хийгээгүй. Яг 1992 оноос хойш өнөөдрийг хүртэл 2000 оны өөрчлөлттэй холбон нийлээд өнөөдрийг хүртэл Үндсэн хуулийн явж байсан тэр зүйл яг амьдрал дээр ямар л зүйл мөрдөж байна тэр зүйл маргааш энэ Үндсэн хуулийн өөрчлөлт болсон ч гэсэн маргааш нь яг хэвээрээ л байна.

Ямар ч зүйл өөрчлөгдөхгүй. Ийм зүйлийгээ тэгээд энэ маш их мөнгө төгрөг гаргаад, энэ ард нийтийн санал асуулга явуулъя гээд ингэж шийдэж байгаа чинь буруу л гэж үзэж байгаа юм.

Ер нь бол эхлээд ард нийтийн санал асуулга явуулахын тулд нэг ээлжит бус сонгуулийг хамт явуулаад ирцийг нь хүргэчихье гэж ярилаа. Их Хурал тараад, энэ нэг бүрэн эрх нь, Их Хурлын гишүүдийн бүрэн эрх нь байхгүй болчих юм бол энэ Их Хурал дотор байгаа 55 гэмт хэрэгтэн чинь бүгдээрээ шоронд явах юм байна гэж айгаад болио биз дээ та нар. Тэрнийгээ болингуутаа та нар 29 тэрбум төгрөгөөр ард нийтийн санал асуулгыг хүмүүст одоо нэгж, зардлыг нь шийдэж байгаад хүмүүсийг ингээд ард нийтийн санал асуулгад оруулах тэр боломжийг нь хангаж, зардал гаргаж байгаад хийе гэж 29 тэрбум төгрөг оруулж ирээд тэрнийгээ баталж чадаагүй нь үнэн биз дээ. Тэгээд хамгийн сүүлд нь одоо бүр аргаа барахаараа 2020 оны сонгуультай

хамтатгаж явуулъя гээд. Та нарын явж байгаа юм чинь ерөөсөө 3 алхахгүй ингээд л мухар нүхэнд ороод байна шүү дээ. 100 жилийн түүхтэй Ардын Нам гээд байгаа. Ямар ч бодлого, холын хараа байхгүй. Ийм л болж хувирч байна шүү дээ. Энэ дээр чинь тэгээд энэ хэтэрхий мөлгөр, ямар ч юм шийдээгүй, ийм Үндсэн хуулийн өөрчлөлтийг чинь ард нийтийн санал асуулгаар баталж болохгүй ээ л гэж Ерөнхийлөгч хориг тавьж байна шүү дээ.

Тэгээд одоо энэ ард түмнээр л шийдүүлнэ. Өөрөөр хэлбэл та нар л за гэж байгаа бол бид нар одоо Үндсэн хуулийн ард нийтийн санал асуулга Үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжиж байна уу, дэмжихгүй байна уу гээд л нэг санал асууна. Тэгэнгүүт ард түмэн за гэхээр та нар за гэсэн юм чинь бид нар ингээд өөрчилчихлөө гэдэг. Ийм л нэг хөгийн богинохон улс төр хийх гээд ингээд наана цаана гарч гүйгээд, янз янзын асуудал яриад ингээд явж байгаа шүү дээ. Тэгээд энэ ард нийтийн санал асуулгыг явуулахыг эсэргүүцэж байна. Энэ одоо Үндсэн хуулийн өөрчлөлтөөр ямар ч зүйл өөрчлөгдөөгүй, яг өнөөдөр яг Үндсэн хууль ямар асуудалтай байна яг тэр хэвээрээ маргааш энэ Үндсэн хуулийн өөрчлөлт хийгдсэн ч гэсэн яг тэр хэвээрээ байна. Тийм учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлт бол ард нийтийн санал асуулгаар явах ямар ч шаардлагагүй ээ гэж үзэж байна.

Х.Нямбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Раднаасэд гишүүнээр тасаллаа. Раднаасэд гишүүний микрофоныг өгөөрэй.

Ш.Раднаасэд: Хоёр, гурван сар зөвшилцөөд яваад байсан тэгээд үр дүн ийм л байгаа юм байна. Нэг ийм буруу ойлголт байна шүү Нямбаатар даргаа. Энэ миний тоолсноор ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолоор зарласан бол зарласнаас хойш 21-45 хоногийн дотор ард нийтийн санал асуулгыг явуулна гэж байгаа. 10 сарын 26-ны өдөр ард нийтийн санал асуулга явуулах хамгийн сүүлийн чинь хугацаа. Та нар тусдаа хуулиар ингээд хугацаагий нь бид нар тогтоочихдог тогтоолоор тогтоочихноо гээд юм яриад яваад байх юм. Одоо 25 хоногийн дараа тэр хугацаа чинь дуусах гэж байна. Энэ 73 дугаар тогтоолоор ард нийтийн санал асуулга явуулах нь зүйтэй гэж тогтсугай гээд зарлачхаж байгаа байхгүй юу. Тэр санал асуулгын тухай хуулийнхаа 7.1-ийг унш. Тэрэн дээр чинь маш тодорхой биччихсэн юм байна лээ. Тэгээд 9 сарын 11-ээс хойш өнөөдрийг болтол ингээд энийгээ нэмээд тооцоод үзэхээр 25 хоногийн дараа ард нийтийн санал асуулга явуулж чадахгүй бол энэ тогтоол чинь хэнд ч хэрэггүй ийм л тогтоол. Ийм байдал руу явчхаж байна. 7.1. Ард нийтийн санал асуулгын тухай хууль. Тэгээд Дэгийн хуулийн нэг ийм хоногийг нь тэгж тогтоно, ингэж тогтоно. Хоног тогтсоноор гэж. Зарласнаас хойш 21-45 хоногийн дотор санал асуулгыг явуулна л гэдэг чинь хугацаа өгөөд, энэ хооронд зохион байгуул, энэ хооронд ямар нэгэн байдлаар тэр ёстой үймээн самуун гаргуулахгүй байх янз янзын юмыг чинь бодож тооцож бодвол бичсэн байх.

Тэгээд энэ хуулийн ашиглалттай, хоногтой юмнууд дээр аль аль талдаа ингээд алдаа оноо гаргачихсан. Одоо хориг тавигдсан. Ингээд энэ нь хэлэлцэж явсаар байтал хэзээ дуусах юм. Ийм мухар юм руу орчихлоо шүү. Одоо өөрөө өөрсдийнхөөрөө өөрийнхөө урд байгаа хуулиа тайлбарлаж явсаар байгаад. Санал асуулга явуулахын тулд тусад нь хууль гаргаж баталсан. Тэгээд тэр хуулийнхаа тэр зүйл, заалтыг та нар ишлэхгүй, тэрийгээ мөрдөхгүйгээр өөр Дэгийн хууль ярьж явж байгаад ингээд ийм байдал руу орчихлоо шүү. Одоо эндээс чинь дахиад маргаан

үүснэ. Үгүй гэвэл Цэц дээр энэ чинь очно. Ийм нөхцөл байдалд очсон. Одоо ёстой жинхэнэ зөвшилцөх цаг чинь болчихсон юм биш үү. Хоёр, гурван сар зөвшилцлөө. Энэ хооронд чинь бараг эрэгтэй, эмэгтэй хоёр танилцаад, гэрлээд хүүхэдтэй болоод одоо хуримаа хийж байна шүү дээ зарим нь. Тийм болтол нь зөвшилцлөө шүү дээ бид. Тэгээд энийгээ одоо яаж ойлгож тайлбарлаад яваад байгааг нь би ерөөсөө ойлгохгүй юм. 2020 оны сонгуультай хамт явуулчихна гээд байх юм. Хаанаас хэн нь тийм санаа олоод хэлчихсэн юм. Тэгвэл энэ хоригоо хүлээж аваад тогтоолоо цуцлаад 2020 оны сонгуулиа зарлах тэр 45 хоногоосоо өмнө дахиад энэ тогтоолоо батлах хэрэгтэй шүү дээ.

Одоо ард нийтийн санал асуулга явуулна гээд ингээд гаргачихсан. Одоо ард түмэн чинь энийг чинь юу гэж байгаа юм бэ гэхээр одоо бусад намууд чинь энийг чинь юу гэж харах юм гэхээр явуулахаа больчихлоо. Эд нар энэний цаана юм хийчихлээ, нуучихлаа, хаачихлаа гэдэг л юм явна. Ингээд нөгөө бушуу туулай борвиндоо баастай гэдэг шиг нэг ийм юм руу явчихлаа. Хууль зүйн байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдсан Үндсэн хууль. Ажлын хэсгийн хуралд намайг лав нэг ч дуудаагүй ээ. Ажлын хэсэгт орсон нэг хэсэг хуульчид ерөнхий хуульчид энэ Мөнх-Оргил, Раднаасэд хоёр орж ирж үгээ хэлээч, юмаа хэлээч гээд ингээд фейсбүүк, твиттерээрээ жаал зарлаад л байна лээ. Нэг ч мессеж, нэг ч хүн над руу утасдаагүй, нэг ч мессеж ирээгүй.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр орж ирээд хоёр, гурван санал хэлсэн. Бүгд хамгаалаад, алдаа ийм юм байгаа бол засчихъя гэж ярихгүйгээр хамгаалаад, дараад муухай хараад ингээд ингээд явчихаар чинь яаж дахиж тэр рүү чинь орж юм хэлэх юм бэ. Эцсийн бүлэгтээ ийм байдал дээр оччихлоо. Одоо энэ асуудал ингээд бүлгийн шийдвэр гарчихсан хүлээж авахгүй гээд. Сая хэвлэлийн мэдээ тавьчихсан байх шиг байна. Тэгээд одоо яах вэ гэдгээ яг эцсийн том зургаар нь харчихсан юм уу. Ийм хүндхэн юм руу орсон шүү.

Х.Нямбаатар: Раднаасэд гишүүн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулж Хууль зүйн байнгын хороон дээр нэгдүгээрт, ажлын хэсэг гараагүй. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдсан. Хоёрдугаарт, Их Хурлын даргын захирамжаар хоёр ажлын хэсэг байгуулагдсан. Гуравдугаарт, та Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг дээр гадаадад байсан. Тэгэхээр одоо яаж энэ. За Төрийн байгуулалтын байнгын хороо тэр Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх, ард нийтийн санал асуулгын хууль зөрчиж байгаа эсэх дээр тайлбарыг Бямбацогт гишүүн та хийх юм уу. Ард нийтийн санал асуулга явуулах хугацаа товлал дээр. 11 сард зохион байгуулах. За баярлалаа. Тэгвэл санал хураалтдаа орёе.

Гишүүд асуулт асууж, үг хэлж хариулт авч дууслаа. Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хурааа.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 4 гишүүн зөвшөөрч, 8 гишүүн татгалзаж, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсангүй ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6-д Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2 буюу 66 хувь нь энэ хоригийг хүлээж аваагүй бол Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр үлдэнэ гэж заасан.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Ганболд гишүүн танилцуулъя.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын даргын 2019 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 177 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцье.

Дарааллын хувьд бол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхээр байсан. Би горим гаргаад эхлээд ажлын хэсгийнхээ дүгнэлтийг хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Гаргасан горимын саналаар санал хураалгая. Санал хураая. Горимын саналыг дэмжье гэсэн.

Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой Их Хурлын даргын захирамжийн ажлын хэсгийг эхэлж дүгнэлтийг нь оруулаад, дараа нь хуулиа хэлэлцээд явъя. Энэ хоёр нэг уялдаатай байгаа учраас гэсэн санал. За санал хураалт. Дэмжигдсэнгүй.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ГЭРЭЭТ АЖИЛТАН

/Б.БААСАНЖАВ/

/Б.УРАНЧИМЭГ/

/Д.ЭНЭБИШ/